



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.06.12 № 01/1061

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД**

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

Тус компаниас 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зарласан ЭТТХК/20240101220 дугаартай "Нүүрс баяжуулах үйлдвэрийн цахилгаан хангамжид зориулагдан баригдаж буй 2\*25МВ чадал бүхий ерөнхий бууруулах дэд станцын ашиглалт, туршилт тохируулгын ажил"-ын гүйцэтгэчийг сонгох тендер шалгаруулалттай холбоотой ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-т: Ажил гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн мэдээллийг цахим систем дэх V бүлэгт заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. ТШЗ 19.2-т: Бусад туслах ажилтны мэдээллийг ирүүлэх ба ажил гүйцэтгэхэд уурхайд бэлэн байлгах үүргийг хүлээх тухай баталгаажуулсан албан бичиг ирүүлнэ гэж заасан.

2. Тендерийн баримт бичгийн 3-р бүлэг, Нүүрс баяжуулах үйлдвэрийн гадна цахилгаан хангамжийн дэд станцад байнгын ашиглалт, засвар үйлчилгээ хийх ажлын даалгаварт зааснаар Загийн усны шугам хоолойн цахилгаан хангамжийн 35/10кВ-ын дэд станцын байнгын ашиглалт, засвар үйлчилгээ, туршилт тохируулгын ажлыг 6 сарын хугацаанд гүйцэтгэх ба 24 цагийн диспетчрийн зохицуулалт хийж шуурхай ажиллагаа явуулан ажиллана.

3. ТШЗ 16.1.2-т: Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй талаарх хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ гэснийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт гэж ойлгоно.

4. Сийрст дэд станц болон Загийн усны шугам хоолойн дэд станцын схем зургийг хавсралтаар хүргүүлэв.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 10.3-т заасны дагуу дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ**



**Х.МӨНХЖАРГАЛ**

**1124041921**